heroal

# heroal – das Aluminium-Systemhaus

Хөнгөн цагааны боловсруулалт хийдэг тэргүүлэх компаниудын нэг нь болохын хувьд Heroal нь эвхэгддэг болон гүйдэг хаалт, жалюз, хаалга, цонх, фасад зэрэг харилцан уялдаатай иж бүрдэл бүтээгдэхүүнүүдийн системийг боловсруулж, үйлдвэрлэн гаргадаг билээ. Heroal системийн шийдэл нь үйлдвэрлэлийн явцад эрчим хүчийг өгөөж өндөртэй ашиглах, хэрэглээний явцад эрчим хүчийг хамгийн багаар хэрэглэж эдийн засгийн үр өгөөжтэй байх нөхцлийг бүрдүүлснээр барилга байгууламжийн үнэ цэнийг нэмэгдүүлж тогтвортой байхад голлох хучин зүйл нь болдог. Үүгээрээ Heroal нь өөрийн байр суурийг бататгаж, ирээдүйн боломж бололцоогоо нээсээр байна.




## Инноваци, Сервис үйлчилгээ, Дизайн, Тогтвортой байдал

Heroal брендийн иж бүрдэл системийн шийдэл нь инноваци шинэчлэлт, сервис үйлчилгээ, бүтээгдэхүүний өндөр чанараараа аливаа барилга архитектурт дизайн, тогтвортой байдлын хослолыг бий болгох стандартыг салбартаа тогтоосоор байна.



Heroal системүүд

Хамгаалалтын жалюз I Цонх I Хаалга I Фасад I Сервис үйлчилгээ

Artikel-Nr. 88399 00 01 I 02.14

**heroal – Johann Henkenjohann GmbH & Co. KG**
Österwieher Str. 80 | 33415 Verl (Germany)
Fon +49 5246 507-0 | Fax +49 5246 507-222
www.heroal.com

**Active Khiits LLC**
Sutai center|Police str.6|Ulaanbaatar|Mongolia
tel: +976 9199 3093; 9199 3310
fax: +976 1135 3539
www.activemon.mn



# heroal C 50 Fassadensysteme
# heroal C 50 Фасадны системүүд

heroal

## Фасадны системүүд

Дээд зэрэглэлийн түүхий эд материалаар орчин үеийн өндөр нарийвчлалтай техникийн дэвшилтэт технологид суурилан барилга архитектурын олон хувилбарт цогц шийдлийг өргөн сонголттойгоор санал болгож чадсанаар бидний давуу тал тодорхойлогддог.

Барилгын гадар өнгөлгөө, үзэмжинд хөнгөн цагаан болон холбох материалуудыг өргөнөөр хэрэглэх болсноор зохион бүтээгч, гүйцэтгэгч, гэрээлэгчдэд олон талын боломж бололцоо, орон зай нээгдэж, жилээс жилд нэмэгдсээр ирлээ. Барилгын салбарынхан энэхүү жишгээр төлөвлөсөн зүйлс, бодол санаагаа амьдралд бодитоор хэрэгжүүлэхэд барилга архитектур, техник шийдэл төдийгүй эдийн засгийн хувьд ч үр өгөөжтэй байх нөхцөл бүрдсэн юм.

Heroal C50 фасадны систем нь эрчим хүчний хэмнэлт, дулаан хадгалах чанараараа зүй ёсоор дэлхийд тэргүүлэх байр суурийг эзэлнэ. Энэхүү систем нь техник шийдлийн хувьд зохиомж загварчлалын ямар нэгэн хязгаарлалтгүйгээр чөлөөтэй бүтээх боломж олгохоос гадна шахалт сайтай тусгаарлагч болон жийргэвч чигжээс зэрэг нь системийг боловсруулах процесс, угсарч суурилуулах, дахин тохиргоо хийх ажиллагаанд олон давуу талууд бий болгодог. Heroal-ын уян хатан олон хувилбарт фасадны систем нь мөн дээвэрлэгээ, саравч хийцлэлийн цогц шийдэлд өргөн хэрэглэгдэж байна.

*Та Heroal фасадны системийн өргөн сонголтыг өөртөө нээнэ үү...*





## Heroal өнгөлгөө, будган хучилтын талаар

Өнгөлгөө, будган хучилт нь heroal системийн салшгүй бүрдэл хэсгийн нэг юм.

Энэ хүрээнд Heroal нь системийн оновчтой зохицолдлогоог хангаж цонх, хаалга, фасад, эвхэгддэг болон хуулидаг хаалт, жалюз г.м. бүхий л хүрээг хамруулж чадсан билээ.

Heroal систем нь өнгөлгөө будган хучилтны өөрийн технологийг хөгжүүлсэн бөгөөд хуурай будагны hwr үелэн будалтны өндөр үр дүнд хүрсэн юм. GSB Premium-Beschichter, Qualicoat Gutsiegel зэрэг албан ёсны шагналууд нь бидний тус салбарт эзлэх байр суурийг илтгэх биз ээ.

Хуурай будган хучилтаас гадна Heroal өөрийн хэрэглэгчиддээ Элоксал хучилт болон гоёлын Ламинатан хучилтыг санал болгодог.

Heroal системийн өнгөлгөө будган хучилтын зохицолдлогоог оновчтой хийснээр түншүүддээ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нийлүүлэлтийг богино хугацаанд хийж өгөх боломж бүрдсэн юм.

## Манай үйлчилгээ таны санал хүсэлтийг тусгал болгон авдаг

Heroal нь хэрэглэгчиддээ өргөн хүрээнд олон төрлийн өөр хоорондоо зохицон нийцдэг багц бүтээгдэхүүний системийг санал болгохоос гадна хэрэглэгчдийнхээ санал хүсэлт шаардлаганд тулгуурласан тусгайлсан сервис үйлчилгээ үзүүлдэг.

Heroal-ын үйл ажиллагааны үндсэн зарчим бол өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн хамт олонд тулгуурлаж хэвтээ интеграцлал болон технологийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан, эрчим хүчний хэмнэлттэй ашигладаг өөрийн үйлдвэрлэлийг Герман улсад явуулж зураг төсөлчид, архитекторууд, барилгачдыг чанарын стандартыг дээд зэргээр хангасан, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй бүтээгдэхүүнээр хангасанаар барилгын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Heroal нь мөн 40,000м2 талбай дээр үйл ажиллагаагаа зохион байгуулж, өөрийн автопарк бүхий бараа бүтээгдэхүүн хуваарилах ложистик төвийг шинээр ашиглалтанд оруулаа.

Бид хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс өөрийн жалюзан хаалт, хаалга, цонх, фасад, тусгайлсан профиль хийцлэл зэрэг бараа бүтээгдэхүүнүүд болон агуулах сервис үйлчилгээндээ Герман улсын Rosenheim ift-ээс чанар стандартын баталгаажилтыг авдаг бөгөөд Heroal нь цэвэр өөрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг хангаж ажилладаг.

Made in Germany heroal

besser lackieren GreenAward FINALIST 2013

# heroal C 50 Fassadensysteme

Optimale Lösungen für jede Anforderung

# heroal C 50 фасадны системүүд

Хэрэгцээ шаардаланд нийцүүлсэн
оновчтой шийдлүүд

Фасадны систем нь барилга архитектурын орчин үеийн үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэхэд өргөн боломж бололцоог нээж өгсөн билээ.

Heroal C 50 фасадны систем нь архитекторууд, барилгын зураг төсөл боловсруулагчид болон гүйцэтгэгчдэд төгс шийдэл гаргах боломж бүрдүүлж чадсан. Харилцан уялдаатай, олон хувилбарт эд ангиудын бүрдэл нь Heroal системийн олон давуу талууд болон уян хатан байдлыг бий болгодог. Уг систем нь дизайн, харагдацын хувь өнгө үзэмжтэйгээс гадна хэрэглээ, ажиллагааны хувьд найдвартай, амьдралд туршигдсан систем юм. Heroal C 50 фасадны системийн уг үндэс нь конструкцийн нэгдмэл төвлөрөлд оршдог.

Бид энэ хүрээнд (heroal C 50) Фасадны олон хувилбарт шийдэлтэй систем, (heroal C 50 ID) Загварлаг ган хийцлэлтэй фасадны систем, (heroal C 50 HI) Өндөр дулаан тусгаарлалттай фасадны систем, (heroal C 50 PH) Пассив хаус сертификатлалтай фасадны систем, (heroal C 50 FP) Галын хамгаалалттай фасадны систем зэрэг цуврал бүтээгдэхүүнүүдээ таньд санал болгож байна.



heroal C 50 Фасадны олон хувилбарт шийдэлтэй систем



heroal C 50 HI Өндөр дулаан тусгаарлалттай фасадны систем



heroal C 50 PH Пассив хаус сертификатлалтай фасадны систем












heroal C 50 FP Галын хамгаалалттай фасадны огтлол зураг




heroal C 50 FP Галын хамгаалалттай фасадны огтлол зураг /гал шилжилтийн бүсэд/

# Фасадны системийн хэмжээс болон шинж чанаруудын харьцуулсан хүснэгт

## Системийн хэмжээс

| Өгөгдөл | heroal C 50 | heroal C 50 HI | heroal C 50 ID | heroal C 50 PH | heroal C 50 FP |
|---|---|---|---|---|---|
| Харагдах өргөн (mm) | 50 | 50 | 50 | 50 | 50 |
| Тулгуурын зузаан (mm) | 28-260 | 28-260 | 95-185 | >115 | 95-185 |
| Хөндлөвчний зузаан (mm) | 6-215 | 6-215 | 6-120 | >120 | 60-190 |
| Шил болон дүүргэлтийн зузаан (mm) | 8-62 | 28-68 | 8-68 | 48 | 22-44 |
| Дүүргэлтийн ачааллах жингийн дээд хязгаар | 450 | 450 | 450 | 380 | 450 |
| Дулаан тусгаарлалт ($U_f$ W/m$^2$K илэрхийлэгдэх) | 1.2-1.7 | 0.78-1.4 | 0.78-1.7 | >0.78 | 1.6-2.2 |
| Хулгайн эсрэг хамгаалалт | WK3 хүртэл | WK2 хүртэл | WK3 хүртэл** | – | – |
| Салхины ачаалал эсэргүүцэх зөвшөөрөгдсөн даац | 2 kN/m$^2$ | 2 kN/m$^2$ | 2 kN/m$^2$ | 2 kN/m$^2$ | 2 kN/m$^2$ |
| Салхины ачаалал эсэргүүцэх дээд даац | 3 kN/m$^2$ | 3 kN/m$^2$ | 3 kN/m$^2$ | 3 kN/m$^2$ | 3 kN/m$^2$ |
| Ус чийг нэвтрүүлэлт | Re1050 | Re1200 | Re1200 | Re1200 | Re1050 |
| Агаар нэвтрүүлэлт | AE* | AE* | AE* | AE* | AE* |
| Цохилт тэсвэрлэлт | I5/E5 | I5/E5 | I5/E5 | I5/E5 | – |
| Дуу чимээ тусгаарлалт | Bis 46db | Bis 49db | Bis 49db | – | – |

* Агаар нэвтрүүлэлт< 0,5 м3/h-m даралт > 600 ПА

** Зөвхөн тодорхой нүүхнүүдын хувьд

## Системийн шинж чанар

| Өгөгдөл | heroal C 50 | heroal C 50 HI | heroal C 50 ID | heroal C 50 PH | heroal C 50 FP |
|---|---|---|---|---|---|
| Тулгуур-Хөндлөвч-Хийцлэл | • | • | • | • | • |
| Дулаан тусгаарлалттай фасад | • | • | • | • | • |
| Дулаан тусгаарлалтгүй дан фасад | • | – | • | – | – |
| Барилгын нэмэлт хийцлэл | • | • | – | – | – |
| Шилэн хорго хийцлэл | • | • | • | – | – |
| Барилга угсралтын элементүүд | • | • | • | – | – |
| Өвлийн хүлэмжний дээвэрлэлт | • | • | – | – | – |
| Дээврийн хучилтын иж бүрдэл | • | • | • | • | – |
| Үйлдвэрлэлийн дизайн | – | • | • | – | – |

## Уялдах элементүүд

| Өгөгдөл | heroal C 50 | heroal C 50 HI | heroal C 50 ID | heroal C 50 PH | heroal C 50 FP |
|---|---|---|---|---|---|
| heroal цонхны элементүүд | • | • | • | – | – |
| heroal блок цонх | • | • | • | – | – |
| heroal хаалганы элементүүд | • | • | • | – | – |
| heroal дээврийн цонхны элементүүд | • | • | • | – | – |





heroal


heroal C50 хуудас 06

Фасадны олон хувилбарт шийдэлтэй систем

heroal C50 ID хуудас 07

Загварлаг ган хийцлэлтэй фасадны систем

heroal C50 HI хуудас 08

Өндөр дулаан тусгаарлалттай фасадны систем

heroal C50 PH хуудас 10

Пассив хаус сертификаттай фасадны систем

heroal C50 FP хуудас 12

Галын хамгаалалттай фасадны систем

# heroal C50

## Фасадны олон хувилбарт шийдэлтэй систем



Дулаан тусгаарлалттай heroal C 50 фасадны систем нь босоо болон хэвтээ тэнхлэгийн хийцлэлд Тулгуур-Хөндлөвч, Тулгуур-Тулгуур болон Хөндлөвч-Хөндлөвч загварчлалаар хийгдэх боломжтой. Энэхүү фасадны системийг мөн дээвэрлэгээ, дээврийн пирамид хорго, өвлийн хүлэмжийн хийцлэлд ашиглагддаг. Дизайн харагдалт сайжруулах болон даац нэмэгдүүлэх нэмэлт профилиуд нь үндсэн системийг баяжуулж, шийдэлийг гүйцээдэг.

Heroal нь дулаан тусгаарлалтын үзэл баримтлалд шинэчлэлт оруулж ирсэн. Өндөр чанартай хөөсөн тусгаарлагч, үл тасалдах жийргэвч нь бүтээгдэхүүн угсралт , тээвэрлэлт болон суулгалтын явцад олон давуу талуудыг бий болгодог. Энэхүү боловсруулалтын давуу талууд нь ялгаатай системүүдийг олон янзын дизайны шийдлэд өөр өөр байдлаар өргөн хэрэглэгддэг. Үүний зэрэгцээ уг систем нь дулаан тусгаарлалтын $U_f$ = 1,2 W/m²K үзүүлэлтийг хангаж чадсан юм. Мөн агааржуулалт болон ус зайлуулалтын хамгийн оновчтой шийдэл өгөх боломжийг хангасан.




heroal C 50 огтлол

### Системийн хэмжээс болон шинж чанар

- » Харагдах өргөн: 50mm
- » Тулгуурын зузаан: 28-260mm
- » Хөндлөвчний зузаан: 6-215mm
- » Шил болон дүүргэлтийн зузаан: 8-62mm
- » Дүүргэлтийн ачааллах жингийн дээд хязгаар: 450kg
- » Дулаан тусгаарлалт: $U_f \geqslant$ 1.2-1.7W/m²K
- » Хулгайн эсрэг хамгаалалт: RC3 хүртэл
- » Салхины ачаалал эсэргүүцэлт: Шаардлага хангасан
- » Ус чийг нэвтрүүлэлт: RE1050
- » Агаар нэвтрүүлэлт: AE
- » Цохилт тэсвэрлэлт: I5/E5
- » Дуу чимээ тусгаарлалт: 46 DB хүртэл

### Гүйцэтгэлийн хувилбарууд ба загвар дизайн

- » Фасадны хувилбарууд: Тулгуур-Хөндлөвч, Тулгуур-Тулгуур, Хөндлөвч-Хөндлөвч
- » Хэлбэр дүрс: Шулуун болон олон өнцөгт
- » Нэмэлт хэрэглээ: Дээвэр хийцлэл, шилэн хорго, өвлийн хүлэмж
- » Системийн уялдаа: Heroal системийн бүх хаалга, цонх, дээврийн салхивч
- » Системийн нэмэлтүүд: Төрөл бүрийн далдлах болон даац нэмэгдүүлэх профилиуд
- » Өнгө дизайн: hwr хуурай будгийн чанартай гоёмсог хучилт







**Isothermenverlauf nach $U_f$ EN ISO 10077-2**



# heroal C50 FP

## Галын хамгаалалттай фасадны систем



Галд тэсвэртэй Heroal C 50 FP фасад хана нь CE тэмдэгтийн шаардлагаар Rosenheim-ын хаалга цонхны технологийн институтын EN 13501-2 нормын дагуу гадна ханаар туршигдаж шалгарсан билээ.

Галын хамгаалалтын бүхийл бүрдэл хэсгүүд нь хийцлэл дотроо агуулагддаг учраас фасад хийцлэлийг тусгайлан хамгаалах шаардлагагүй байдаг.

Уг галын хамгаалалттай фасад хана нь Heroal C 50 фасадны үндсэн систем дээр суурьладаг бөгөөд EI 30 i<>o нормоор өргөтгөгдсөн байдаг.

Үндсэн болон нэмэлт бүрдэл хэсгүүд тэр дотроо патентлагдсан гал тусгаарлах блок материалууд нь галын аюулаас хамгаалах өндөр зэрэглэлтэй фасад бүтээх нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь CE тэмдэгтийн дагуу хийгддэг.

### Системийн хэмжээс болон шинж чанар

- Харагдах өргөн: 50mm
- Тулгуурын зузаан: 95-185mm
- Хөндлөвчний зузаан: 60-190mm
- Шил болон дүүргэлтийн зузаан: 22-44mm
- Дүүргэлтийн ачааллах жингийн дээд хязгаар: 450kg
- Дулаан тусгаарлалт: $U_f \geqslant$ 1.6-2.2W/m$^2$K
- Салхины ачаалал эсэргүүцэлт: 2kN/m$^2$ /зөвш./, 3kN/m$^2$ /дээд/
- Ус чийг нэвтрүүлэлт: RE1050
- Агаар нэвтрүүлэлт: AE
- Гал тэсвэрлэлт: EI30

### Гүйцэтгэлийн хувилбарууд ба загвар дизайн

- Гаднах харагдалт: Heroal C 50 загвартай ижил харагдалттай
- Фасадны хувилбарууд: Тулгуур-Хөндлөвч, Тулгуур-Тулгуур, Хөндлөвч-Хөндлөвч
- Хэлбэр дүрс: Шулуун болон олон өнцөгт
- Нэмэлт хэрэглээ: Дээвэр хийцлэл зэрэг зарим хэсэглэлд
- Системийн нэмэлтүүд: Төрөл бүрийн далдлах болон даац нэмэгдүүлэх профилиуд
- Өнгө дизайн: hwr хуурай будгийн чанартай гоёмсог хучилт





"ХӨНГӨН ЦАГААНААР ОЛОН ТӨРЛИЙН ЮМ ХИЙДЭГ. ХАРИН БИД ТҮҮГЭЭР АРАЙ ОНЦГОЙ ЗҮЙЛ ХИЙДЭГ."



# heroal C50 HI

## Өндөр дулаан тусгаарлалттай фасадны систем



Өндөр дулаан тусгаарлалттай Heroal C50 HI систем нь фасад хананд 3 давхар шилэн багц хийх нөхцлийг бүрдүүлснээр Пассив хаус хэрэглээг бий болгох нөхцөл бүрдүүлсэн юм.

Энэ нь он удаан жилийн хэрэглээ даахаас гадна эрчим хүч хэмнэлтийн үзэл баримтлалд гайхалтай өөрчлөлт авчирсан.

Дизайн хийцлэлийн тусгай бүрдэл хэсгүүд нь хурдан шуурхай угсралт суурилуулалт хийх, аюулгүй ажиллагааг хангасан эдийн засгийн хэмнэлттэй үйлдвэрлэл явуулах боломжийг нээж өгсөн.

Мөн энэхүү фасадны системийн чанартай тусгай хөөсөн тусгаарлагч, үл тасалдах жийргэвч хийцлэл нь бусдаас ялгарах бас нэг онцлог нь болдог.




heroal C50 HI  Огтлол

### Системийн хэмжээс болон шинж чанар

- Харагдах өргөн: 50mm
- Тулгуурын зузаан: 28-260mm
- Хөндлөвчний зузаан: 6-215mm
- Шил болон дүүргэлтийн зузаан: 28-62mm
- Дүүргэлтийн ачааллах жингийн дээд хязгаар: 450kg
- Дулаан тусгаарлалт: $U_f \geqslant$ 0.78-1.4W/$m^2$K
- Хулгайн эсрэг хамгаалалт: RC2 хүртэл
- Салхины ачаалал эсэргүүцэлт: 2kN/$m^2$ /зөвш./, 3kN/$m^2$ /дээд/
- Ус чийг нэвтрүүлэлт: RE1200
- Агаар нэвтрүүлэлт: AE
- Цохилт тэсвэрлэлт: I5/E5
- Дуу чимээ тусгаарлалт: 49 DB хүртэл

### Гүйцэтгэлийн хувилбарууд ба загвар дизайн

- Фасадны хувилбарууд: Тулгуур-Хөндлөвч, Тулгуур-Тулгуур, Хөндлөвч-Хөндлөвч
- Хэлбэр дүрс: Шулуун болон олон өнцөгт
- Нэмэлт хэрэглээ: Дээвэр хийцлэл, шилэн хорго, өвлийн хүлэмж
- Системийн уялдаа: Heroal системийн бүх хаалга, цонх, дээврийн салхивч
- Системийн нэмэлтүүд: Төрөл бүрийн далдлах болон даац нэмэгдүүлэх профилиуд
- Өнгө дизайн: hwr хуурай будгийн чанартай гоёмсог хучилт







heroal C 50 HI + heroal W 72 i

# heroal C50 PH

## Пассив хаус сертификаттай фасадны систем



Heroal C 50 PH фасадны систем нь өндөр дулаан тусгаарлалттай Heroal C 50 HI фасадны системийн сайжруулж хөгжүүлсэн хувилбар бөгөөд Тулгуур-Хөндлөвч гүйцэтгэлтээр дулаан тусгаарлалтын үзүүлэлт $U_f$-ыг 0.78W/m$^2$K болтол бууруулж чадсан билээ. Энэ ч утгаараа фасадны хавтанлалт болон шиллэгээний үзүүлэлтээрээ Пассив хаус сертификат авсан.

Гагцхүү дулаан тусгаарлалтын хамгийн сүүлийн үеийн технологи болон материалыг оновчтой хэрэглэснээр Heroal дулаан тусгаарлагч модулийн дулааны алдагдлын хэмжээг хамгийн бага үзүүлэлтэнд хүргэж чадсан юм. Чанартай тусгай хөөсөн тусгаарлагч болон үл тасалдах жийргэвч хийцлэл нь дулаан тусгаарлалтын шинэ стандартыг тогтоогоод байна.




heroal C50 PH Оглтол

### Системийн хэмжээс болон шинж чанар

- Харагдах өргөн: 50mm
- Тулгуурын зузаан: ⩾115mm
- Хөндлөвчний зузаан: >120mm
- Шил болон дүүргэлтийн зузаан: 48mm
- Дүүргэлтийн ачааллах жингийн дээд хязгаар: 380kg
- Дулаан тусгаарлалт: $U_f \geqslant$ 0.78W/m$^2$K
- Салхины ачаалал эсэргүүцэлт: 2kN/m$^2$ /зөвш./, 3kN/m$^2$ /дээд/
- Ус чийг нэвтрүүлэлт: RE1050
- Агаар нэвтрүүлэлт: AE
- Цохилт тэсвэрлэлт: I5/E5

### Гүйцэтгэлийн хувилбарууд ба загвар дизайн

- Гаднах харагдалт: Heroal C 50 загвартай ижил харагдалттай
- Фасаны хувилбарууд: Тулгуур-Хөндлөвч
- Хэлбэр дүрс: Шулуун болон олон өнцөгт
- Системийн уялдаа: Heroal системийн бүх хаалга, цонх, дээврийн салхивч
- Системийн нэмэлтүүд: Төрөл бүрийн далдлах болон даац нэмэгдүүлэх профилиуд
- Өнгө дизайн: hwr хуурай будгийн чанартай гоёмсог хучилт





# heroal C50 ID

## Загварлаг ган хийцлэлтэй фасадны систем



Heroal C 50 ID фасадны систем нь үйлдвэрлэлийн дизайны хүрээнд цоо шинэ шийдэл, бүтээлч загварчлалыг авчирсан юм. Энэ нь барилгын зураг төсөлчид, архитекторууд болон төсөл хэрэгжүүлэгч нарт өндөр шаардлаганд нийцсэн гүйцэтгэлийг амьдралд хэрэгжүүлэх боломж олгох болсон.

Дулаан тусгаарлалтын шинэчлэгдсэн үзэл баримтлалаар чанартай тусгай хөөсөн тусгаарлагч болон үл тасалдах жийргэвч хийцлэл нь үйлдвэрлэлийн загварчлалд стандарт болон хэрэглэгдэж байна.

Фасадны бодитоор хүлээн зөвшөөрөгдөхүйц дизайн харагдац болон Heroal-ын бусад системүүдтэй төгс уялдах байдал нь өндөр чанар болон уян хатан загварчлал бий болгох үндэс нь болж өгдөг.




heroal C 50 ID оглтол

### Системийн хэмжээс болон шинж чанар

- Харагдах өргөн: 50mm
- Тулгуурын зузаан: 95-185mm
- Хөндлөвчний зузаан: 60-120mm
- Шил болон дүүргэлтийн зузаан: 8-68mm
- Дүүргэлтийн ачааллах жингийн дээд хязгаар: 450kg
- Дулаан тусгаарлалт: $U_f \geqslant$ 0.78-1.7W/m$^2$K
- Хулгайн эсрэг хамгаалалт: WK3 хүртэл
- Салхины ачаалал эсэргүүцэлт: 2kN/m$^2$ /зөвш./, 3kN/m$^2$ /дээд/
- Ус чийг нэвтрүүлэлт: RE1200
- Агаар нэвтрүүлэлт: AE
- Цохилт тэсвэрлэлт: I5/E5

### Гүйцэтгэлийн хувилбарууд ба загвар дизайн

- Фасадны хувилбарууд: Тулгуур-Хөндлөвч
- Хэлбэр дүрс: Шулуун болон олон өнцөгт
- Нэмэлт хэрэглээ: Дээвэр хийцлэл, шилэн хорго, өвлийн хүлэмж
- Системийн уялдаа: Heroal системийн бүх хаалга, цонх, дээврийн салхивч
- Системийн нэмэлтүүд: Төрөл бүрийн далдлах болон даац нэмэгдүүлэх профилиуд
- Өнгө дизайн: hwr хуурай будгийн чанартай гоёмсог хучилт